



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 06 сарын 05 өдөр

Дугаар 81

Сүхбаатар

Шагналын журмыг шинэчлэн  
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 3 дахь хэсгийн а,в заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

- 1."Аймгийн шагналын журам"-ыг хавсралтаар баталсугай.
- 2.Энэ журмыг 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

3.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2002 оны 29 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Ж.САНЖЖАВ





Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2014 оны 06 дугаар сарын 05-ны  
өдрийн 81 дүгээр тогтоолын хавсралт

## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ШАГНАЛЫН ЖУРАМ

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1 Улс эх орон, Сэлэнгэ аймгийн хөгжил дэвшлийн төлөө олон жилийн хөдөлмөр бүтээлээ зориулсан, эрхэлсэн ажилдаа тогтвортой амжилт гаргаж ажил үйлс, авъяас билэг, ур чадвараараа шалгарсан тэргүүний хүмүүсийг урамшуулах, иргэдийн хөдөлмөрлөх, бүтээх идэвх санаачлагыг өрнүүлэхэд шагналын зорилго оршино.

### **Хоёр. Аймгаас олгох шагнал**

2.1 Аймгийн хөгжил, дэвшил, нийгмийн сайн сайхны төлөө оруулсан хөдөлмөр бүтээл, аймгийн нэр хүндийг олонд дуурсгасан амжилт, гавъяат үйлсийг үнэлж, хөхүүлэн урамшуулах шагнал. Үүнд:

а/ Аймгийн “Хүндэт иргэн” өргөмжлөл, тэмдэг

б/ Аймгийн “Хүндэт тэмдэг”, үнэмлэх

в/ Аймгийн ИТХ-ын “Хүндэт өргөмжлөл”

г/ Аймгийн Засаг даргын “Сэлэнгийн алдар” медаль, үнэмлэх

д/ Аймгийн Засаг даргын “Жуух бичиг”

2.1.1 Аймгийн “Хүндэт иргэн” өргөмжлөл, тэмдгээр аймаг, улс орны эдийн засаг, нийгмийн хөгжил, бүтээн байгуулалтад онцгой хувь нэмэр оруулсан, хөдөлмөр, урлаг, спортын гарамгай амжилт гаргаж, Сэлэнгэ аймгийг Улс, Тив, Дэлхийн хэмжээнд алдаршуулж олон түмэнд хүндлэгдсэн Монгол Улсын иргэнийг шагнана. Мөн аймгийн гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд онцгой амжилт гаргасан гадаадын иргэнийг шагнаж болно.

2.1.2 Аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үйлсэд олон жилийн хүч хөдөлмөрөө зориулж онцгой хувь нэмэр оруулсан, амжилт гаргасан иргэнийг шагнана. Мөн аймгийн хөгжилд хувь нэмэр оруулсан гадаадын иргэн, гадаад, дотоодын өндөр хэмжээний зочин төлөөлөгчийг шагнаж болно.

2.1.3 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэт өргөмжлөл”-өөр аймгийн эдийн засаг, нийгмийн салбарын хөгжилд бодитой хувь нэмэр оруулж амжилт гаргасан сум, байгууллага, иргэнийг шагнана.



2.1.4 Аймгийн Засаг даргын “Хүндэт өргөмжлөл”-өөр орон аймгийн эдийн засаг, нийгмийн салбарын хөгжилд бодитой хувь нэмэр оруулж амжилт гаргасан сум, байгууллага, иргэнийг шагнана.

2.1.5 Аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр эрхэлсэн ажилдаа олон жил үр бүтээлтэй ажиллаж, эсвэл онцгой амжилт гаргасан иргэнийг шагнана.

2.2 Олон жилийн болон тухайн жилийн ажлын амжилт бүтээлийг үнэлж оны тэргүүнээр шалгаруулж шагнах шагнал. Үүнд:

- а/ Аймгийн “Тэргүүний хамт олон” өргөмжлөл
- б/ Аймгийн “Тэргүүний ажилтан” үнэмлэх тэмдэг
- в/ Аймгийн “Сайн малчин” үнэмлэх тэмдэг
- г/ Аймгийн “Шилдэг уяач” үнэмлэх тэмдэг
- д/ Аймгийн “Тэргүүний тариаланч” үнэмлэх тэмдэг
- е/ Аймгийн “Тэргүүний сурагч” үнэмлэх тэмдэг

2.2.1. “Тэргүүний хамт олон” “Тэргүүний ажилтан”, “Сайн малчин”, “Тэргүүний тариаланч” “Тэргүүний сурагч”, “Шилдэг уяач” нь эрхэлсэн ажил үүргийн хувьд дараах болзол, шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байна. Үүнд:

#### **Аймгийн тэргүүний хамт олон**

1.Аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үйлсэд бодитой хувь нэмэр оруулсан байх

2.Хариуцсан салбартаа өрсөлдөхүйц хэмжээний тогтвортой амжилт үзүүлсэн байх

3.Тухайн жилийн салбарын болон аймаг, орон нутгийн дэвшүүлсэн зорилтын хэрэгжилтийг бүрэн хангаж, байгууллагынхаа нийгмийн асуудлыг тодорхой түвшинд шийдвэрлэсэн байх.

#### **Аймгийн “Тэргүүний ажилтан”**

1.Эрхэлсэн ажил албандаа олон жил тогтвортой амжилт гаргаж тухайн жилийн ажлаараа аймагтаа тэргүүлсэн ажилтныг аймгийн тэргүүний ажилтнаар шалгаруулж шагнана.

2. Тэргүүний ажилтныг дараах салбар чиглэлээр шалгаруулна. Үүнд:

- а/ Төрийн захиргаа /нийгмийн хамгаалал, байгаль орчин/
- б/ Боловсрол



- в/ Эрүүл мэнд
- г/ Соёл урлаг
- д/Биеийн тамир, спорт
- е/ Аялал жуулчлал
- ё/ Санхүү, эдийн засаг
- ж/ Худалдаа, үйлчилгээ
- з/ Үйлдвэрлэл
- и/ Зам тээвэр /Авто зам, Төмөр зам/
- й/ Эрчим хүч /Дулаан, цахилгаан, Урсгал ус/
- к/ Хууль, хяналт

#### **Аймгийн “Сайн малчин”**

1. Малын тоог сүүлийн 3 жилд тогтвортой хэмжээнд байлгаж, оны эхэнд байсан хээлтэгч нэг бүрээс төл бүрэн хүлээн авсан байх.
2. Сүргийн зохистой бүтцийг харгалзаж, хээлтэгчийн тоо тогтвортой нэмэгдэж, нийт сүрэгт эзлэх хувийн жин бог малд 50, бод малд 35-аас доошгүй хувьд хүрсэн байх.
3. Мал сүргээ халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулж, эрүүл сүрэгтэй болсон байх.
4. Эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамрагдсан байх.
5. Мал сүргийнхээ ашиг шимийг нэмэгдүүлж, аймгийн хэмжээнд тэргүүлэх амжилт гаргасан байх.

#### **Аймгийн Шилдэг уяач**

Тухайн жилийн улсын болон аймгийн баяр наадам, орон нутгийн чанартай бүсийн уралдаанд уяж уралдуулсан морь нь түрүүлж, айрагдсан уяачийг гаргасан амжилтаар нь аймгийн Шилдэг уяачаар шалгаруулна.

#### **Аймгийн “Тэргүүний тариаланч”**

1. Газар тариалангийн үйлдвэрлэлд сүүлийн 3 жилд дараалан жил бүр га тутмаас хураан авсан үр тарианы ургац нь усалгаагүй талбайд 13 цн, усалгаатай талбайд 30 цн-ээс доошгүй байх
2. Төмсний ургац нь усалгаагүй талбайд 110 цн, усалгаатай талбайд 200 цн-ээс доошгүй байх



3. Сүүлийн 3 жил дараалан жил бүр га тутмаас байцаа 250 цн, үндэс үрт ногоо 120 цн, сонгинолог ургамал 80 цн, хамгаалагдсан хөрсний 1 метр квадрат талбай тутмаас өргөст хэмх -15 кг, улаан лооль 10 кг-аас доошгүй ургац хураан авсан байх

4. Малын тэжээлийн ургац нь усалгаагүй талбайд 30 цн, усалгаатай талбайд 60 цн-ээс доошгүй байх

5. Сүүлийн 3 жил дараалан жил бүр комбайнаар шууд хураалтад шилжүүлснээр 400 га, трактороор 1200 жишмэл га-гаас доошгүй ажил гүйцэтгэсэн байх.

#### **Аймгийн Тэргүүний сурагч**

Сурлагын үнэлгээ "А" үнэлгээтэй суралцаж байгаа сургуулийнхаа шилдэг сурагчаар шалгарсан, дараахь шалгуур үзүүлэлтийг хангасан сурагчид нэр дэвшинэ.

1. Судалж байгаа хичээлээрээ: аймгийн олимпиадад эхний 5, улсад эхний 10-н байрт шалгарсан байх

2. Аймгийн хэмжээнд зохиогдсон спорт, урлагийн тэмцээнд хувийн болон багийн амжилтаар эхний 5-н байрт шалгарсан байх

3. Олон нийтийн ажилд идэвх, санаачилгатай манлайлан оролцдог байх

#### **Гурав. Аймгийн шагналд тодорхойлох**

3.1. Сумын Засаг дарга болон нутгийн захиргааны байгууллагын /хэлтэс, агентлагийн/ удирдлага нь шагнуулах хүний анкет, ажил байдлын тодорхойлолт, хамт олны хуралдааны тэмдэглэл болон бусад холбогдох материалыг аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ.

3.2. Ирүүлсэн санал, тодорхойлолтыг аймгийн Засаг даргын Тамгын газрын харъяалах хэлтсүүд судалж нягтлан санал боловсруулж холбогдох газарт хүргүүлнэ.

#### **Дөрөв. Аймгийн шагналаар шагнах асуудлыг шийдвэрлэх**

4.1. Энэхүү журмаар зохицуулагдсан шагналаар шагнах асуудлыг сумын Засаг дарга, нутгийн захиргааны байгууллагын удирдлагын тодорхойлолт, харъяалах хэлтсийн саналыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хамтран болон тус тусдаа хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:



а/ Аймгийн “Хүндэт иргэн”-д өргөмжлөхөөр сум, байгууллагаас ирсэн саналаас гадна аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, аймгийн Засаг дарга нэр дэвшүүлж болно. Аймгийн “Хүндэт иргэн”-д өргөмжлөх асуудлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэнэ. Аймгийн “Хүндэт иргэн”-ий өргөмжлөл дээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нар гарын үсэг зурна.

б/ Аймгийн Засаг дарга аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр шагнуулах саналаа иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид аймгийн Засаг даргын оруулсан саналыг хэлэлцээд аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр шагнах тухай тогтоол гаргана. “Хүндэт тэмдэг”-ийн үнэмлэх дээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нар гарын үсэг зурна.

в/ Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэт өргөмжлөл”-өөр шагнах асуудлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын захирамжаар шийдвэрлэнэ.

г/ Аймгийн Засаг даргын “Сэлэнгийн алдар” медаль, “Жуух бичиг”-ээр шагнах асуудлыг аймгийн Засаг даргын захирамжаар шийдвэрлэнэ.

4.2. “Тэргүүний хамт олон” “Тэргүүний ажилтан”, “Сайн малчин”, “Тэргүүний тариаланч”, “Тэргүүний сурагч”, “Шилдэг уяач”-ийн шалгаруулалтыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

***Тав. Аймгийн шагнал, дагалдах мөнгөн шагналыг олгох***

5.1. Аймгийн “Хүндэт иргэн” өргөмжлөгдсөн иргэнд Өргөмжлөл, тэмдэг, 1.0 сая төгрөг олгоно.

5.2. Аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр шагнагдсан иргэнд тэмдэг, үнэмлэх, 30.0 мянган төгрөг олгоно.

5.3. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэт өргөмжлөл”-ийн дагалдах мөнгөн шагнал нь 30.0 мянган төгрөг байна.

5.4. Аймгийн Засаг даргын “Сэлэнгийн алдар” медалиар шагнагдсан иргэнд медаль, үнэмлэх олгоно.

5.5. Аймгийн Засаг даргын жуухаар шагнагдсан иргэнд “Жуух бичиг”, 10.0 мянган төгрөг олгоно.

5.6. Аймгийн “Тэргүүний хамт олон”-оор шалгарсан байгууллагад өргөмжлөл, 300,0 мянган төгрөг олгоно,

5.7 Аймгийн “Тэргүүний ажилтан”, “Сайн малчин”, “Тэргүүний тариаланч”, “Тэргүүний сурагч”-аар шалгарсан иргэнд өргөмжлөл, тэмдэг, тус бүр 100.0 мянган төгрөг олгоно.

5.8 Аймгийн “Шилдэг уяач” хүртсэн уяачид өргөмжлөл, 100,0 мянган төгрөг олгоно.

***Зургаа. Шагналын сан***

6.1. Шагналын санг аймгийн төсөвт тусгагдаж батлагдсан хөрөнгөөр бүрдүүлнэ.

6.2. Шагналын сангийн хэмжээг жил бүр аймгийн төсөвт тусган иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна.

----- оОо -----